



## АШУУИС-ИЙН ДАДЛАГЫН НЭГДСЭН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар АШУУИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтад хамрагдаж байгаа мэргэжлийн бүх салбарын оюутны үйлдвэрлэлийн, эмнэлзүйн, технологийн, танилцах болон эрдэм шинжилгээний туслах ажилтны дадлагыг хийх, түүнийг удирдах багш, зохион байгуулах мэргэжлийн тэнхим, сургалтын алба, нэгж болон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах үндсэн журам болно.

### Хоёр. Дадлагын удирдлага, ерөнхий зохион байгуулалт

- 2.1 Оюутны дадлагыг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, улсын төв эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, хувийн эмнэлэг, их сургуулийн эрдэм шинжилгээний лаборатори болон тусгай мэргэжлийн эмнэлэг, төвүүдийн болон хүрээлэнгийн судалгааны лаборатори, мэргэжлийн хяналтын ерөнхий газрын лаборатори, эмийн үйлдвэр, эмийн сангуудад батлагдсан удирдамжийн хүрээнд бүрэлдэхүүн, салбар сургуулиуд зохион байгуулна.
- 2.2 Дадлага хийх байгууллагатай бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал урьдчилан гэрээ хийсэн байна.
- 2.3 Дадлага удирдах багшид ноогдох оюутны тоо хөдөө орон нутагт 15-аас дээш, Улаанбаатар хотод 40 хүртэл байхаар зохион байгуулна.
- 2.4 Хөдөө орон нутагт дадлага хийх оюутны тоо 15-аас бага байгаа тохиолдолд гэрээний дагуу удирдах багшийг тухайн байгууллагаас томилон ажиллуулна.
- 2.5 Бүрэлдэхүүн сургуулийн сургалт хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн тэнхимүүд дадлагын удирдамж, тайлан хамгаалалтын загвар, цахим бүртгэлийн зааврыг боловсруулан, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар баталгаажуулан, хичээлийн жилийн 1-р улирлын эхэнд сургуулийн цахим хуудсанд байршуулна.
- 2.6 Бүрэлдэхүүн сургуулиудын арга зүйчид жил бүрийн 10 сарын 05, 5-р сарын 20-ны дотор дадлага хийх оюутнуудын нэрс, удирдах багш, хуваарийг гарган, ТӨСА-д ирүүлнэ.
- 2.7 Мэргэжлийн тэнхимийн хурлын тэмдэглэлийг үндэслэн жилд 1-ээс доошгүй багшийг ээлжлэн томилж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.8 Дадлага эхлэхийн өмнө оюутан дадлагын удирдамжаа багшдаа өгч бүрдгүүлнэ.
- 2.9 АШУУИС-тай хамтын ажиллагааны гэрээ бүхий олон улсын байгууллага, гадаадын их дээд сургуулиудад дадлага хийх болон тус сургуульд ирж дадлага хийх тохиолдолд холбогдох гэрээ, хүсэлт, урилга болон бусад албан материалыг үндэслэн Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар, Гадаад



харилцаа хамтын ажиллагааны газартай хамтран дадлагыг зохион байгуулах ба багц цагийг тооцно.

- 2.10 Гадаад орны их, дээд сургуулиас тус сургуульд ирж дадлага хийх хүсэлтэй суралцагчдын холбогдох материалыг дадлага эхлэхээс 3-аас доошгүй сарын өмнө их сургуулийн Гадаад харилцаа хамтын ажиллагааны газар хүлээн авна.
- 2.11 Гадаад оюутнууд тус сургуульд дадлага хийж байгаа тохиолдолд (оюутан солилцооны хөтөлбөрийн дагуу дадлага хийх оюутнуудад хамаарахгүй) дадлагын төрөл, хугацаанаас хамаарч багц цагийн төлбөрийг их сургуулийн дансанд тушаасан байна.
- 2.12 Оюутан дадлагыг үндсэн харьяаллын дагуу хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд 1 сарын өмнө бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн хуваарийг өөрчлөх боломжтой.

### **Гурав. Дадлагын явцын хяналт, үнэлгээ**

- 3.1. Хүндэтгэх шалтгаангүйгээр дадлага хийгээгүй, дадлага дууссанаас хойш 7 хоногийн дотор тайлан хамгаалалт хийгээгүй, дадлагын 20-оос дээш хувьд оролцоогүй, дадлагыг удирдамжийн дагуу хийгээгүй, тайлан хамгаалалтад хангалтгүй буюу 60%-аас бага үнэлгээ авсан бол дадлагыг тооцохгүй.
- 3.2. Дадлага удирдсан багш оюутны тайлан хамгаалалтын дүнг 9 сарын 15-ны дотор багтаан ИСУМС-д оруулж, бүрэлдэхүүн сургуулийн арга зүйч нь тайлан хамгаалалтын нэгдсэн дүнг Төгсөлтийн өмнөх сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- 3.3. Хүндэтгэх шалтгаанаар /ар гэрийн гачигдал, хүнд өвчтэй байсан, хүн асрамжилсан, төрсөн/ дадлага хийгээгүй, тайлан хамгаалалтад ороогүй, дадлагын хөтөлбөрийн шаардлага хангаагүй оюутнууд дараагийн хичээлийн жилд үргэлжлүүлэн хийж болно..
- 3.4. Улсын болон сургуулийн нэрийн өмнөөс олон улсын тэмцээн, уралдаан, олимпиадад оролцсон, хүндэтгэх шалтгаанаар /ар гэрийн гачигдал, хүнд өвчтэй байсан, хүн асрамжилсан, төрсөн/ дадлага хийгээгүй оюутнуудад төлбөргүй нөхөлт хийнэ.
- 3.5. Дадлагыг удирдсан багш, эмч нар оюутнуудын дадлага хийсэн өдөр, цаг, ажлын тэмдэглэлийг шалган тамга, гарын үсгээр баталгаажуулна.

### **Дөрөв. Дадлага удирдах багшийн үүрэг, хариуцлага**

- 4.1 Дадлага удирдаж буй багш нь оюутанд тухайн эмнэлгийн байгууллагууд, мэргэжлийн хяналтын газар, лаборатори, эмийн үйлдвэр, эмийн сангуудад ажиллах дотоод журмыг танилцуулан, эмнэлэгт ажиллах чиглэл, хувцаслалтын талаар зааварчилгаа өгөх



- 4.2 Оюутан нэг бүрийг дадлагын удирдамжийн дагуу ажиллуулах
- 4.3 Дадлагын хугацаанд оюутнуудаар анагаах ухааны ололт амжилтыг тусгасан реферат, мэдээлэл хийлгэх, самбар гаргуулах ажлыг зохион байгуулах
- 4.4 Олон нийтийн дунд эрүүл аж төрөх ёс, өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг удирдан зохион байгуулах
- 4.5 Хөдөө орон нутагт дадлага удирдах АШУҮИС-ийн үндсэн багш нь өөрийн мэргэжлийн чиглэлээр үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, эмгэг анатомийн хуралд биечлэн оролцож, эмч, сувилагч, мэргэжилтэн нарт сургалт явуулах.
- 4.6 Дадлагын явцад оюутан нэг бүрийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, тайлангийн хугацаа дуусахад дадлага ажлын дэвтэрт үнэлгээ өгч тайлан хамгаалалтыг зохион байгуулах

---oOo---